



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 14

Арвайхээр

Ёс зүйн хороо байгуулах тухай


Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын хоёрдугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Ёс зүйн хорооны дарга: А.Отгонцэцэг –Хууль эрх зүйн хэлтсийн дарга  
Нарийн бичгийн дарга: -Л.Ишханд –Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн  
Гишүүд: -Н.Энхцэцэг –Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга  
-Г.Баясгалан –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга  
-Р.Наранцэцэг –Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн салбарын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

2. Ёс зүйн хорооны ажлын төлөвлөгөө боловсруулан, төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, ёс зүйн зөрчлийн тухай мэдээг хагас, бүтэн жилээр танилцуулж ажиллахыг Ёс зүйн хороо (А.Отгонцэцэг)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

013100033

D:My Doc.tool TAZ